



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: contact@ub-procurement.mn  
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.11.05 № 03/2061

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зарласан НХААГ/20240102629 дугаартай "Эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, Жаргалант тосгон)" нийлүүлэх тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгын хариуг дараах байдлаар хүргүүлж байна.

№	Сонирхогч этгээдийн тодруулга	Захиалагчийн хариу
1	Тендерийн баримт бичгийн бараа нийлүүлэлтийн хуваарьт гэрээ байгуулснаас хойш 45 гэж заасан байна. Гадаад улсад үйлдвэрлэгдэн импортоор ханган нийлүүлэгдэх бараа бүтээгдэхүүний хувьд хамгийн багадаа 45-60 хоногийн хугацаанд, харин нарийн нийлмэл бүтэц бүхий лабораторийн тоног төхөөрөмжийн хувьд 65-90 хоногт үйлдвэрлэж, тухайн улсаас 20-30 хоногт тээвэрлэгдэн эцсийн хэрэглэгчийн гарт хүртлээ нийт дунджаар 120 хоног зарцуулагдана. Тус тендер шалгаруулалтад бидний санал болгож буй тоног төхөөрөмж нь гадаад улсад шинээр үйлдвэрлэгдэх бөгөөд урьд өмнө ашиглагдаж байгаагүй, хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг агуулсан байх тул хамгийн ихдээ хуанлийн 120 хоногийн дотор үйлдвэрлэгдэж, импортоор орж ирэх тул тендерийн ерөнхий шаардлагад байх бараа нийлүүлэлтийн хугацаа нь гэрээ байгуулснаас хойш 45 хоног гэж заасныг бараа нийлүүлэлтийн үед захиалагч талтай тохиролцон сунгаж болох эсэхэд тодруулга хийж өгнө үү.	-Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг гэрээ байгуулснаас хойш 45 хоног гэснийг; -Гэрээ байгуулснаас хойш 90 хоногийн дотор гэж өөрчилж байна.
2	Тус тендерийн ТШББ-ийн ТШЗ 24.1-д "тендерийн баталгааны үнийн дүн: 146.500 төгрөг" гэж заасан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.1 заалтад "багцгүй тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 саяас дээш бол тендерийн баталгаа шаардана" гэж заасан байх тул бидний оролцож буй уг тендер шалгаруулалтад тендерийн баталгаа заавал	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх хэсгийг үндэслэн тус тендер шалгаруулалтад тендерийн баталгаа шаардахгүй болгож өөрчлөв.

	шаардаж буй эсэх тодруулга хийж өгнө үү.	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 24.1 Тендерийн баталгаа: "Шаардана" Тендерийн баталгааны дүн: 146,500 төгрөг гэснийг; Тендерийн баталгаа: "Шаардахгүй" гэж өөрчлөв.
3	Тус тендерийн техникийн үзүүлэлт хэсэг дэх урвалжийн шаардлагад үсгийн фонтоос үүдэлтэй алдаа гарсан харагдаж байх тул захиалагч нь гематологийн аппаратын урвалжийн техник үзүүлэлтийг дахин нягталж, техник үзүүлэлтэд засвар оруулж болох эсэхэд тодруулга хийж өгнө үү?	Захиалагчаас шинэчлэн баталсан Гематологийн аппаратын техникийн тодорхойлолтыг хавсралтаар оруулав.
4	Тухайн тоног төхөөрөмж нь бүрэн автомат эсвэл хагас автомат ажиллагаатай эсэх. -Тендерийн техникийн тодорхойлолтод зааснаар ажиллагаа нь бүрэн автомат гэсэн боловч Хүчин чадал (40 тест/цаг) болон бусад үзүүлэлт нь хагас автомат 3-Парт анализаторыг тодорхойлолт үзүүлэлт бөгөөд автомат сорьц ачаалагчийн үзүүлэлт байхгүй байна.	
5	Шинжилгээний параметр болон Ашиглах урвалжийн мэдээллийг тодорхой болгож өгнө үү. -Ашиглах урвалжийн мэдээлэл болон тоо ширхэг нь тодорхой биш бөгөөд үүн дээр заасан үзүүлэлт нь шинжилгээний параметруудийг илтгэж байна.	

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт заасны дагуу дараах өөрчлөлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт оруулж байна.

№	Өмнөх заалт	Өөрчилсөн заалт
1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.1, 26.2 дахь хэсэг. -Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 10 цаг 00 минут; -Тендерийн нээлт: 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 10 цаг 30 минут гэснийг;	-Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 10 цаг 00 минут; -Тендерийн нээлт: 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 10 цаг 30 минут гэж өөрчлөв.

Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Хавсралт 3 хуудастай.



Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар  
Удирдлага  
Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
Даваадорж Батцэцэг  
2024.11.06 12:24